

Хөвсгөл, Хатгал, 1-р хэсэг, Хатгал тосгон.
Улаанбаатар оффис, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Гутал ХК байр.
Утас: 976 7577-8888, 8888-3550
И-мэйл: urjinbadam.ch@nomin.net
Вэб: www.nomin.mn

2023 оны 01 дүгээр
сарын 27-ны өдөр

Дугаар: 01

Улаанбаатар
хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн хувьцааг нэгтгэх, компанийг
хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон
өөрчлөх төсөл батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.4, 62.1.6, 62.1.15 дахь хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 01-р сарын 27-ны өдрийн ээлжит бус хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

- Төлөөлөн удирдах зөвлөлөөс өргөн барьсан “Хөвсгөл усан зам” ХК-ийн хувьцааг нэгтгэх, тус компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх төсөл”-ийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
- Төслийн хэрэгжилтийг зохион байгуулахыг уг ажлыг гүйцэтгүүлэх зорилгоор компанийн төлөөлөх удирдах зөвлөлөөс томилсон комисс болон гүйцэтгэх захирал Ч.Үржинбадам нарт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

М.ӨЛЗИЙБАТ



“Хөвсгөл усан зам” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
2023 оны 01-р сарын 27-ны өдрийн ээлжит
бус хурлын 01 тоот тогтоолын хавсралт

**“ХӨВСГӨЛ УСАН ЗАМ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААГ НЭГТГЭХ, ТУС
КОМПАНИЙГ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
БОЛГОН ӨӨРЧЛӨХ ТӨСӨЛ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү төсөл (цаашид “Төсөл” гэх) нь “Хөвсгөл усан зам” хувьцаат компани (цаашид “ХК”, эсхүл “Компани” гэх)-ийг Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “СЗХ” гэх), Монголын хөрөнгийн бирж (цаашид “МХБ” гэх)-ээс баталсан холбогдох журмын дагуу Компанийн хувьцааг нэгтгэх, “Хөвсгөл усан зам” хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид “ХХК” гэх) болгон хэлбэр өөрчлөх замаар Компанийг өөрчлөн зохион байгуулах, үүнтэй холбоотойгоор хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулж, холбогдох шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдийн шаардах эрхийг хэрэгжүүлэх, Компанийн хувьцааг СЗХ болон МХБ-ийн үнэт цаасны бүртгэлээс хасуулах, ХХК-ийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад чиглэгдэнэ.

1.2. Төслийн гол онцлог нь түүнийг хэрэгжүүлснээр хувьцаа эзэмшигчдийн тэр дундаа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хөндөгдөхгүй байх тал дээр анхаарлаа голлон хандуулсанд оршино. Өөрөөр хэлбэл, жижиг хувьцаа эзэмшигчид энэхүү Төсөлд заасан нөхцөл журмын дагуу өөрийн сонголтоор ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр үлдэх, эсхүл хувьцаагаа Компанид эргүүлэн худалдах эрхтэй байх бөгөөд хэрэв ХХК-ийн хувьцаа эзэмшигч хэвээр үлдэхийг сонгосон тохиолдолд ХХК-ийн нийт хувьцаанд тэдний эзлэх хувь хэмжээ буурахгүй болно.

**Хоёр. Компанийн тухай товч танилцуулга,
Компанийг өөрчлөх, хувьцааг нэгтгэх зорилго, шалтгаан**

2.1. Компанийн танилцуулга:

Компани нь Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд Хөвсгөл нуурын эрэг дээр Усан замын тээвэр, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг Монгол Улсын ууган аж ахуйн нэгжүүдийн нэг юм.

Анх 1932-1934 онд Дорнод Сибирийн усан замын газрын удирдлага зохион байгуулалт дор 120 тн-ын даацтай, 60 зорчигч тээвэрлэх “Сүхбаатар” хөлөг онгоц, тус бүр 250 тн даацтай хуурай ачааны “Малчин”, шатахуун тээвэрлэх “Ажилчин” нэртэй чиргүүл онгоцнуудыг барьж ашиглалтад оруулан, иж бүрэн хөвөх бүрэлдэхүүнтэй болсон ба Хөвсгөл нуурыг хамгаалах зарим арга хэмжээний тухай БНМАУ-ын Засгийн газрын 1989 оны 186 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор шатахуун тээвэрлэхийг зогсоож, бааз байгууллагууд татан буугдаж, өөр газруудад шилжсэн зэргээс 1991 оноос Хөвсгөлийн усан замын газрын үйл ажиллагаа үндсэндээ зогссон байсан юм.

Улмаар Хөвсгөл аймгийн өмч хувьчлалын комиссын 1993 оны 18 дугаар тогтоолоор Усан замын газрыг төрийн өмч давамгайлсан “Хөвсгөл Усан Зам” ХК болгон зохион байгуулж хувьцааг МХБ-ээр дамжуулан нийтэд арилжаалсан байдаг. 1997 онд Засгийн газрын 160 дугаар тогтоолыг үндэслэн Компанийн хувьцааг дуудлага худалдаагаар “ТАС” ХХК худалдан авсан бөгөөд хожим Компанийн одоогийн томоохон хувьцаа эзэмшигчид 2005 онд Компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авч, хувьцаа эзэмшигч болсон. Энэ цагаас хойш Компани нь аялал жуулчлалыг хөгжүүлэхэд онцгой анхаарч, Монгол Улсад усан замын үйл ажиллагаа эрхэлж байгаа цорын ганц аж ахуйн нэгж болсон юм.

2.2. Компанийг өөрчлөх зорилго, шалтгаан:

Доорх бодит нөхцөл байдал, шалтгааны улмаас Компанийг өөрчлөх шаардлага үүссэн болно. Үүнд:

2.2.1 Компанийн үнэт цаасны хөрвөх чадвар хангалтгүй, арилжааны идэвх муу болсон:

Компанийн хувьцааны хөрвөх чадвар, арилжааны идэвх сүүлийн 3 жил буюу 2019, 2020, 2021 оны байдлаар хангалтгүй болсон тул 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр МХБ-ийн зүгээс Компанийг “Үнэт цаасны хөрвөх чадвар хангалтгүй, арилжаа нь идэвх муу компани” болохыг тогтоож, МХБ-ийн үнэт цаасны бүртгэлээс хасагдах нөхцөл үүссэн 94 хувьцаат компаниудын нэг болохыг зарласан байdag¹.

Компанийн хувьд МХБ-ийн арилжаанд хөндлөнгөөс нөлөөлөх, идэвхжүүлэх арга хэмжээ авах боломжгүй, мөн Компанийн том хувьцаа эзэмшигчид дахин хувьцаа худалдан авах, эсхүл хувьцаагаа худалдах сонирхолтгүй байх тул Компанийн үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулах, арилжааг идэвхжүүлэх боломжгүй байна.

Өөрөөр хэлбэл, МХБ-ийн 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн мэдэгдэлд дурдсанчлан МХБ-ийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018-01 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам” (цаашид “МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журам” гэх)-ын 23.11 дэх хэсэгт “Үнэт цаасны хөрвөх чадвар муудсан, Биржээс тогтоосон шалгуур, шаардлагыг биелүүлж чадахгүй болсон нь тогтоогдсон ... болон хууль журамд заасан бусад үндэслэлээр үнэт цаасыг Биржийн бүртгэлээс хасна” гэж заасны дагуу Компанийг МХБ-ийн бүртгэлээс хасуулах хууль зүйн үндэслэл үүсээд байна.

2.2.2 Хувьцаа эзэмшигчдийн идэвх оролцоо сул:

Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх ба Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Хувьцаа эзэмшигчид нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хуралд идэвхтэй оролцсоноор Компанийн засаглал сайжирч, Компанийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тухай бүр харилцан зөвшлилцлийн үндсэн дээр шийдвэрлэх ач холбогдолтой байдаг. Гэтэл Компанийн хувьд сүүлийн 3 жилийн хувьцаа эзэмшигчдийн

¹ МХБ-ийн 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн мэдэгдэл: <https://mse.mn/mn/news/9076>

хуралд нийт 196 хувьцаа эзэмшигчээс 5 хувьцаа эзэмшигч л Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тогтмол оролцсоор иржээ. Тухайлбал:

Хамгийн сүүлийн буюу Компанийн 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд Компанийн нийт хувьцааны 31.94 хувийг эзэмшигч 1 хувьцаа эзэмшигч, 32.17 хувийг эзэмшигч 1 хувьцаа эзэмшигч, 25 хувийг эзэмшигч 1 хувьцаа эзэмшигч, тус бүр 0.04 хувийг эзэмшигч 2 хувьцаа эзэмшигч, нийт 5 хувьцаа эзэмшигч оролцсон.

2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд Компанийн нийт хувьцааны 31.94 хувийг эзэмшигч 1 хувьцаа эзэмшигч, 32.17 хувийг эзэмшигч 1 хувьцаа эзэмшигч, 25 хувийг эзэмшигч 1 хувьцаа эзэмшигч, 0.04 хувийг эзэмшигч 1 хувьцаа эзэмшигч, 0.12 хувийг эзэмшигч 1 хувьцаа эзэмшигч, нийт 5 хувьцаа эзэмшигч оролцсон

2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд Компанийн нийт хувьцааны 31.94 хувийг эзэмшигч 1 хувьцаа эзэмшигч, 32.17 хувийг эзэмшигч 1 хувьцаа эзэмшигч, 25 хувийг эзэмшигч 1 хувьцаа эзэмшигч, 0.12 хувийг эзэмшигч 1 хувьцаа эзэмшигч, 0.14 хувийг эзэмшигч 1 хувьцаа эзэмшигч, нийт 5 хувьцаа эзэмшигч оролцсон.

Ийнхүү нийт 196 хувьцаа эзэмшигчтэйгээс 5 хувьцаа эзэмшигч л тогтмол хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа нь хэдий хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцох ирцийн хувьд хүрч байгаа боловч нийт хувьцаа эзэмшигчдийн 2.5% нь л Компанийн үйл ажиллагаа буюу хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгааг харуулж байна. Ийнхүү хувьцаа эзэмшигчдийн идэвх оролцоо сул байгаа нь хувьцаат компани байхын ач холбогдлыг бууруулж байна.

2.2.3 Компанийн санхүүгийн чадавх буурсан:

Компани нь олон жилийн турш санхүүгийн алдагдалтай ажиллаж ирсэн ба одоогийн байдлаар нийт хүлээгдэж буй өр төлбөрийн хэмжээ 3,718,161,215.01 /гурван тэрбум долоон зуун арван найман сая нэг зуун жаран нэгэн мянга хоёр зуун арван таван төгрөг нэг мөнгө/ төгрөг байна. Компани нь 2019 оны байдлаар 3,492,574,300 төгрөгийн, 2020 оны байдлаар 3,510,560,600 төгрөгийн, 2021 оны байдлаар 3,556,062,500 төгрөгийн хуримтлагаас алдагдалтай ажилласан байдаг².

Компани нь хувьцаат компаниар бүртгэгдэж, ХК-аар үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш нэг ч удаа ногдол ашиг тарааж байгаагүй нь компанийн санхүүгийн чадвар илтэд буурсныг харуулдаг.

2.3 Хувьцаа нэгтгэх зорилго, шалтгаан:

2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн тархалтын судалгаагаар³ Компани нь нийт 196 хувьцаа эзэмшигчтэйгээс 3 том хувьцаа эзэмшигчид нь 84,147 ширхэг хувьцаа буюу Компанийн нийт гаргасан хувьцааны 89.11 хувийг эзэмшиж байна. Үлдсэн 193 хувьцаа эзэмшигч нь 10,279 ширхэг хувьцаа буюу Компанийн нийт гаргасан хувьцааны 10.88 хувийг эзэмшиж байна.

² 2019, 2020, 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг үндэслэв.

³ 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн тов" ХХК-ийн тархалтын судалгаагаар;

Дээрх 2.2 дахь хэсэгт дурдсанаар Компанийн үнэт цаасны хөрвөх чадвар хангалтгүй, арилжааны идэвх муудсан, жижиг хувьцаа эзэмшигчдийн идэвх оролцоо сул, санхүүгийн чадавх суларсан, ногдол ашиг тараах боломжгүй зэрэг нөхцөл байдлын улмаас жижиг хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцаа нь эдийн засгийн үр ашиг, өгөөж өгдөггүй үхмэл хөрөнгө болоод байгаа билээ. Тэгвэл хувьцааг нэгтгэнээр зарим жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцаа нь бутархай болох ба Компанийн тухай хуулийн 51.4, МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 19.2-д тус тус заасны дагуу жижиг хувьцаа эзэмшигчийн эрхийг хангах үүднээс Компани ТУЗ-өөс тогтоосон үнээр бутархай хувьцааг эргүүлэн худалдан авах хууль зүйн боломж бүрдэнэ. Ийнхүү бутархай хувьцаатай зарим жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааг Компани эргүүлэн худалдан авснаар тэдний үхмэл хувьцаа нь мөнгөн хөрөнгөнд хөрвөж, тэдгээр хувьцаа эзэмшигч нар уг мөнгөн хөрөнгөө эдийн засгийн эргэлтэд оруулах (тухайлбал, өгөөжтэй өөр санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах) боломж бүрдэх юм.

Түүнчлэн, дээр 2.2.2 дахь хэсэгт дурдсанаар Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд 5-аас ихгүй хувьцаа эзэмшигчид оролцдог ба бусад хувьцаа эзэмшигчид хуралд оролцоггүй, идэвхгүй байдалтай байдаг. Компанийн хэлбэр ХК-иас ХХК-руу өөрчлөгдөх үед ХХК-д идэвхгүй 190 хүртэлх тооны хувьцаа эзэмшигч байх нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах, хувьцаагаа худалдах, шилжүүлэх, шийдвэрийг улсын бүртгэлд бүртгүүлэх зэрэг тохиолдолд хүндрэл бэрхшээл үүсгэх эрсдэлтэй. Тухайлбал, ХХК-ийн аль нэг хувьцаа эзэмшигч хувьцаагаа бусдад худалдах, эсхүл шилжүүлэх тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжид хувьцаа худалдан авах эрхийг эдлүүлэх шаардлага үүсэх бөгөөд нийт 195 хувьцаа эзэмшигч наарт санал хүргүүлэх, хариу цуглуулах хэрэгцээ гарна. Эдгээр 195 хувьцаа эзэмшигчдийн заримынх нь хаяг тодорхойгүй, зарим нь хариу өгөхгүй буюу өгсөн ч саналын дагуу хувьцааг авахгүй байх зэрэг хүндрэл бэрхшээл, тохиолдол үүсэж болно.

Өөрөөр хэлбэл хувьцааг нэгтгэн, Компанийг өөрчлөн байгуулах тохиолдолд идэвх оролцоо сул, Компанид хувьцаа эзэмшигчээр үлдэх санал гаргаагүй жижиг хувьцаа эзэмшигчдийг Компаниас гаргах ба ингэхдээ ногдол ашиг олгодоггүй, хөрвөх чадвар муутай үнэт цаасыг ТУЗ-өөс тогтоосон үнээр худалдан авч, тухайн хувьцаа эзэмшигчийн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг хувьцаа нэгтгэх арга бүрдүүлж байгаа юм.

Хувьцааг нэгтгэх үед хувьцааг эргүүлэн худалдан авахыг шаардах эрх үссэн, шаардлага гаргасан хувьцаа эзэмшигчдээс хувьцааг эргүүлэн худалдан авна (дэлгэрэнгүйг доорх 5 дахь хэсгээс үзнэ үү). Харин Компанийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т заасны дагуу шаардлага гаргаагүй хувьцаа эзэмшигчдийн хувьцааг шинээр өөрчлөн байгуулагдах ХХК-ийн хувьцаа руу хөрвүүлэх ба нэгтгэх үед бутархай хувьцаатай болсон хувьцаа эзэмшигч бутархай тооны хувьцаагаа Компанид худалдах, эсхүл нэмж хөрөнгө оруулан бүхэлдэх боломжийг Компани олгоно (дэлгэрэнгүйг доорх 5 дахь хэсгээс үзнэ үү).

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах

3.1 Компанийн хувьцааг нэгтгэх, Компанийг ХХК болгон өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит бус хурал (цаашид “Хурал” гэх)-аар хэлэлцэж шийдвэрлэнэ.

3.2 Хурлыг хуралдуулах, хурлын зар мэдээг хүргэх ажлыг Компанийн төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТҮЗ" гэх)-өөс байгуулсан хурал зохион байгуулах комисс Компанийн тухай хууль, СЗХ-ны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ыг мөрдөж зохион байгуулна.

Дөрөв. Хувьцаа нэгтгэх, компанийг өөрчлөн байгуулах хууль зүйн үндэслэл

4.1 Иргэний хуулийн 31 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 18, 23 дугаар зүйл, МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 23.1 дүгээр зүйлд хувьцаат компанийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хязгаарлагдмал хариуцлагатай компани болон өөрчлөгдөж, үнэт цаасаа бүртгэлээс хасуулж болох талаар, Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйл, СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 5.7 дугаар зүйл, МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 19 дүгээр зүйлд компанийн хувьцааг нэгтгэх талаар тус тус зохицуулсан нь Компанийн хувьцааг нэгтгэх, Компанийг өөрчлөх эрх зүйн үндэслэл болно.

4.2 Компанийн хувьцааг нэгтгэх мөн ХХК болгон өөрчлөх замаар өөрчлөн зохион байгуулах, үнэт цаасыг нь бүртгэлээс хасуулах үйл ажиллагааг Компанийн тухай хууль, бусад хууль тогтоомж, СЗХ болон МХБ-ээс баталсан холбогдох журмуудыг мөрдөж гүйцэтгэнэ.

Тав. Компанийн хувьцааг нэгтгэх, хөрвүүлэх болон Компанийн хэлбэрийг өөрчлөх нөхцөл, журам, хувьцаа эргүүлэн худалдан авах журам

5.1. Компанийн хувьцааг нэгтгэх, хэлбэрийг өөрчлөх төслийг хэрэгжүүлэх ажиллагааг ТҮЗ-өөс томилсон комисс (цаашид "Комисс" гэх) эрхлэн гүйцэтгэнэ. Комисс нь хувьцаа эзэмшигч болон МХБ, СЗХ-нд шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь хүртээмжтэй хүргүүлэх, Төслийг Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон СЗХ, хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоосон нөхцөл, журмын дагуу хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

5.2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн хувьцааг нэгтгэх, ХХК болгон өөрчлөх төслийг хэлэлцэж Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд нийцүүлж шийдвэр гаргана.

5.3. Компанийн тухай хуулийн 69.1, Компанийн дурмийн 7.4-д заасны дагуу Компанийн саналын эрхтэй нийт хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор Компанийн хувьцааг нэгтгэх, Компанийн хэлбэрийг өөрчлөх асуудлыг хэлэлцэж буй хурал хүчин төгөлдөр болно. Компанийн тухай хуулийн 20.4, 23.2, 63.7-д заасны дагуу Компанийн хувьцааг нэгтгэх, Компанийн хэлбэрийг өөрчлөх асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.

5.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Компанийн хувьцааг нэгтгэх, ХХК болгон өөрчлөхөөр шийдвэр гарсан тохиолдолд бүртгэлээс хасуулах хүсэлтийг тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын З хоногийн дотор холбогдох баримт бичгийн хамт МХБ-д хүргүүлнэ. Тус хугацааны дотор хурлын материалыг СЗХ-нд мөн хүргүүлнэ.

5.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Компанийн хувьцааг нэгтгэх шийдвэр гарсан тохиолдолд Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.4, МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 19.2-д заасны дагуу нэгтгэсний үр дүнд бий болсон хувьцааны бутархай үлдэгдлийг тухайн бутархай тооны хувьцаатай хувьцаа эзэмшигчийн саналыг үндэслэн (i) ТУЗ-өөс тогтоосон үнээр Компани эргүүлэн худалдан авах, эсхүл (ii) бутархай тооны хувьцаатай хувьцаа эзэмшигч Компанид нэмж хөрөнгө оруулалт хийж, Компани түүнд тохирох тооны хувьцаа нэмж гарган, эсхүл халаасалсан хувьцаанаас гарган эзэмшүүлэх замаар бутархай тооны хувьцааг бүхэлдэж болно. Хоёр дахь тохиолдолд бутархай тооны хувьцаатай байсан хувьцаа эзэмшигч нь бүхэл хувьцаатай болж ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр үлдэх ба хувьцаа эзэмшигчийн Компанид эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээ буурахгүй, харин тодорхой хэмжээгээр өснө. Тодруулбал, хувьцааг нэгтгэх замаар ХХК-ийн хувьцаа руу хөрвүүлэхэд тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй ХК-ийн хувьцаа ХХК-ийн бүхэл хувьцаанд хүрэхгүй тохиолдолд тухайн хувьцаа эзэмшигч ХХК-ийн хувьцаа эзэмшигч болох хүсэлт гаргаж, Компаниас өөрийн хувьцааг бүхэл болгоход хүрэлцэхгүй байгаа хэмжээний хувьцааг худалдан авах эрхтэй. Ийнхүү худалдан авах хүсэлт гаргаагүй хувьцаа эзэмшигчдийн хувьцааг энэ Төслийн 5.18-д заасны дагуу Компани “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн дансанд менгэ байршуулах замаар худалдан авна.

Жишээ 1: ХК-ийн [232] ширхэг энгийн хувьцааг ХХК-ийн 1 ширхэг энгийн хувьцаа болгон нэгтгэн хөрвүүлэхэд [232] ширхгээс доош хэмжээний хувьцаа, жишээлбэл [100] ширхэг хувьцаа эзэмшдэг жижиг хувьцаа эзэмшигчийн ХК-ийн хувьцаа ХХК-ийн 1 ширхэг хувьцаанд хүрэхгүй [0.43] ширхэг ХХК-ийн энгийн хувьцаа байх бөгөөд тухайн хувьцаа эзэмшигч бутархай тооны хувьцааг бүхэлдэх хүсэлтээ Төслийн 5.8-д заасан хугацааны дотор гаргаагүй, эсхүл хувьцаагаа Компанид эргүүлэн худалдах санал гаргасан бол Компани нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн дансанд тухайн хувьцааны төлбөрийг ТУЗ-өөс тогтоосон үнээр тооцон байршуулж, хувьцааг эргүүлэн худалдан авна.

Жишээ 2: ХК-ийн [232] ширхэг энгийн хувьцааг ХХК-ийн 1 ширхэг энгийн хувьцаа болгон нэгтгэн хөрвүүлэхэд [232] ширхгээс доош хэмжээний хувьцаа, жишээлбэл [100] ширхэг хувьцаа эзэмшдэг жижиг хувьцаа эзэмшигчийн ХК-ийн хувьцаа ХХК-ийн 1 ширхэг хувьцаанд хүрэхгүй [0.43] ширхэг ХХК-ийн энгийн хувьцаа байх тул ХХК-ийн [0.57] ширхэг энгийн хувьцаанд тохирох хэмжээний хөрөнгө оруулалтыг ТУЗ-өөс тогтоосон үнийн дагуу нэмж оруулах замаар ХХК-ийн 1 бүхэл хувьцаатай болж, ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр үлдэнэ. Тус хувьцаа эзэмшигч нь хүсэлтээ Төслийн 5.8-д заасан хугацааны дотор гаргана.

Түүнчлэн, хувьцааг нэгтгэсний үр дүнд 1 ширхгээс дээш тооны гэхдээ бутархай хувьцаатай хувьцаа эзэмшигч нь бутархай хувьцаагаа бүхэл болгохын тулд ТУЗ-өөс тогтоосон үнийн дагуу нэмж хөрөнгө оруулах замаар бүхэл болгож болно, эсхүл ТУЗ-өөс тогтоосон үнийн дагуу бутархай хувьцаагаа Компанид эргүүлэн худалдаж болно.

5.6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Компанийн хувьцааг нэгтгэх, ХХК болгох шийдвэр гарсан тохиолдолд Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.1, 53.1.3-д заасны дагуу хурлаас гаргасан шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч нь Компанид хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардах эрхтэй байна. Компанийн тухай хуулийн 53.4-д заасны дагуу тус шаардах

эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэrsийн жагсаалтыг уг эрх үүссэн өдөр Компанийн үnэт цаасны бүртгэлд байсан мэдээллийг үндэслэн гаргана.

5.7. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдаж, Компанийн хувьцааг нэгтгэх, Компанийг ХХК болгох шийдвэр гарсан тохиолдолд Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцааг эргүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулна.

5.8. Компанийн хувьцааг нэгтгэх болон хэлбэр өөрчлөх үед Компанийн хувьцаа эзэмшигч бүр нь ХХК-д хувьцаа эзэмшигчээр үлдэх эрхтэй байна. Компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтэй, эсхүл хувьцаагаа Компанид эргүүлэн ТУЗ-өөс тогтоосон үnээр худалдах хүсэлтэй хувьцаа эзэмшигч нь энэ тухай хүсэлтээ энэ төслийн 5.9-д заасан зар анхлан нийтлэгдсэн өдрөөс хойш ажлын 30 хоногийн дотор гаргах ёстой ба тус хугацаанд гаргаагүй бол энэ төслийн 5.18-д заасны дагуу түүний хувьцаанд ногдох мөнгөн хөрөнгийг түүний дансанд нь шилжүүлж, түүнийг ХХК-ийн хувьцаа эзэмшигчээс хасна.

5.9. "Үnэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-иас гаргаж өгдөг хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанаас үзэхэд хувьцаа эзэмшигчдийн хаяг тодорхойгүй байдаг тул хувьцаа эзэмшигч бүрт Компанийн хувьцааг нэгтгэх, Компанийг өөрчлөх тухай шийдвэр гарсан, хувьцаа эзэмшигч нь ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр үлдэх эрхтэй тухай болон хувьцаагаа эргүүлэн авахыг Компаниас шаардах эрх үүссэн тухай зарыг хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэдэг СЗХ-ны журмын дагуу өдөр тутам хэвлэгдэн гардаг сонин, орон даяар нэвтрүүлгээ хүргэдэг телевизээр, Компанийн болон МХБ-ийн цахим хуудсаар тус бүр 2-оос доошгүй удаагийн давтамжтайгаар хүргэнэ. Энэхүү зарыг Компанийн хувьцааг үnэт цаасны бүртгэлээс хасах тухай СЗХ-ны шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор сонин, телевиз, Компанийн болон МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэнэ.

5.10. Компанийн тухай хуулийн 54.3-д заасны дагуу бүх хувьцаа эзэмшигчдэд бичгээр мэдэгдэл хүргүүлэх боломжгүй тул энэ төслийн 5.9-д заасны дагуу шаардах эрх үүссэн тухай олон нийтэд анх мэдээлсэн өдрөөс хойш ажлын 30 хоногийн дотор хувьцаагаа эргүүлэн худалдан авах шаардлагыг хувьцаа эзэмшигчдээс бичгээр хүлээн авна. Компанийн тухай хуулийн 54.2-д заасны дагуу хувьцаагаа эргүүлэн авахыг шаардсан хувьцаа эзэмшигч нь шаардлагадаа эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа хаяг, эргүүлэн авахыг шаардаж буй хувьцааны тоо, төрлийг заасан байна.

5.11. Компанийн хувьцааг нэгтгэх, Компанийг ХХК болгон өөрчлөх төслийг баталсан хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигчийн гаргасан шаардлагын дагуу түүний хувьцааг эргүүлэн худалдаж авах болон Төслийн дагуу ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр үлдэх санал гаргаагүй хувьцаа эзэмшигчийн хувьцаанд ногдох хөрөнгийг данс руу нь шилжүүлэхэд тус тус ашиглагдах уг компанийн нэгж хувьцааны үнийг ТУЗ тогтооно. Ингэхдээ ТУЗ нь Компанийн тухай хуулийн 55.7-д заасны дагуу хараат бус үnэлгээний байгууллага болон аудитын байгууллагын дүгнэлт зэргийг харгалзана.

5.12. Хувьцаа эзэмшигчийн хувьцааг эргүүлэн худалдан авах ажиллагааг үnэт цаасны компанийтай гэрээ байгуулан, гэрээний дагуу хэрэгжүүлнэ. Үnэт цаасны компанийтай холбогдох хаяг, утсыг энэ төслийн 5.9-д заасан зард тусгасан байна.

5.13. Үnэт цаасны компани нь иргэд, аж ахуйн нэгжийн хувьцааг худалдан авахдаа тэдгээрээс энэ төслийн 5.10-д заасан шаардлага (шаардлага гаргасан тохиолдолд), тухайн иргэн, аж ахуйн нэгжийн иргэний үnэмлэх, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, итгэмжлэлийг авч үлдэнэ.

5.14. Хувьцаа эзэмшигчид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхээ хэрэгжүүлэх хугацаа нь энэ эрх үссэн тухай нийтэд анх мэдээлсэн өдөр буюу энэ төслийн 5.9-д заасан зарыг анх нийтэлсэн өдрөөс хойш ажлын 30 хоног байна. Үnэт цаасны компани нь шаардах эрх гаргасан хувьцаа эзэмшигч нарт хувьцааны төлбөрийг нь шилжүүлэн, тус ажлын 30 хоногийн хугацаа дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор хувьцаа эргүүлэн худалдан авсан тайланг Компанид ирүүлнэ.

5.15. Хувьцаагаа эргүүлэн худалдахыг хүссэн иргэн бүр иргэний үnэмлэх, адилтгах бичиг баримт (жолооны үnэмлэх, гадаад паспорт)-тай үnэт цаасны компани дээр ирэх бөгөөд ийм бичиг баримтгүй тохиолдолд хувьцааг эргүүлэн худалдаж авахгүй. Аж ахуйн нэгжийн хувьд улсын бүртгэлийн гэрчилгээ, эсхүл түүний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар болон аж ахуйн нэгжийг төлөөлж хувьцааг худалдан, мөнгийг нь хүлээн авах бүрэн эрхтэйг нотолсон баримт бичиг (итгэмжлэл)-тэй ирэх бөгөөд ийм бичиг баримтгүй тохиолдолд хувьцааг эргүүлэн худалдаж авахгүй.

5.16. Хувьцааг эргүүлэн авсан тухай баримтад тухайн иргэн, аж ахуйн нэгжийн гэрийн, албаны болон гар утасны дугаар, гэрийн болон ажлын хаягийг тусган, иргэний баримт бичиг, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, итгэмжлэл зэргийг хавсаргана.

5.17. Гэрээ байгуулсан үnэт цаасны компаниар дамжуулж хувьцаагаа худалдсан иргэн, аж ахуйн нэгжийн жагсаалтыг "Үnэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-аас гаргасан жагсаалттай тулган хүлээн авах ажиллагааг ТУЗ, эсхүл түүнээс томилсон комисс хариуцан гүйцэтгэнэ.

5.18. Энэ төслийн 5.10-д заасан хугацаанд хувьцаагаа эргүүлэн авахыг шаардаагүй, эсхүл Төслийн 5.8-д заасан хугацаанд ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлт гаргаагүй хувьцаа эзэмшигчийн хувьцаанд ногдох мөнгөн хөрөнгийг Төслийн 5.11-д заасны дагуу ТУЗ-өөс тогтоосон хувьцааны үnээр тооцон гаргаж, "Үnэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК дахь дансанд байршуулна.

5.19. Төслийн 5.10-д заасан хугацаа өнгөрсөн боловч Компанийн хувьцаа эзэмшигч нь Төслийн 5.18-д заасан мөнгийг авалгүйгээр ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг хэдийд ч гаргаж болно. Ийм хүсэлт гаргасан тохиолдолд ХХК нь уг хүсэлтийг хангах үүрэг хүлээнэ.

5.20. Төслийн 5.14 болон 5.18-д заасны дагуу үnийг нь хувьцаа эзэмшигч нарт төлж, шилжүүлэн авсан хувьцаа нь Компанийн халаасны хувьцаа болно. Компани нь бутархай хувьцаагаа бүхэлдэх санал гаргасан хувьцаа эзэмшигчид халаасалсан хувьцаанаас хувьцаа гарган эзэмшүүлж болно.

5.21. СЗХ-ноос Компанийн хувьцааг бүртгэлээс хасахыг зөвшөөрсөн тогтоол гарснаас хойш мөн энэхүү Төслийн 5.8 болон 5.10-д заасан хугацаа дууссаны дараа ТУЗ нь ХХК-ийн зэлжит бус анхны хурлыг зарлах, зохион байгуулахдаа Компанийн тухай хуульд заасан нийтлэг журмыг баримтална. ХХК-ийн дүрмийг батлах тухай хувьцаа эзэмшигчдийн шийдвэр гарснаас хойш ажлын 15 өдрийн дотор дүрмийн шинэчилсэн найруулгыг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлнэ. ХХК-ийн дүрмийн төслийг Хавсралт 1-ээс үзнэ үү.

5.22. ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал шаардлагатай гэж үзсэн тохиолдолд ХХК-ийн удирдах байгууллагыг шинэчлэн баталж болно.

Зургаа. Хувьцааг хөрвүүлэх арга, тооцоо

6.1 Энэхүү төслийн дагуу Компанийн хувьцааг нэгтгэх, хэлбэрийг өөрчлөх нөхцөлд Компанийн **944.26** ширхэг энгийн хувьцааг **1** шинэ энгийн хувьцаанд хөрвүүлэх замаар нэгтгэх ба хувьцаа нэгтгэсний үр дүнд Компанийн одоогийн **94,426** ширхэг энгийн хувьцаа нь **100** (нэг зуун) ширхэг энгийн хувьцаа болж нэгтгэгдэнэ. Хувьцааны нэрлэсэн үнэ нь **3,736** (гурван мянга долоо зуун гучин зургаан) төгрөг байсан бол **3,527,755.36** (гурван сая таван зуун хорин долоон мянга долоон зуун тавин таван төгрөг гучин зургаан мөнгө) төгрөг болж өөрчлөгднө.

6.2 Компанийн хувьцаа эзэмшигч бүрийн эзэмшиж буй хувьцааг дээр 6.1-д заасны дагуу адил аргаар нэгтгэж, ХХК-ийн хувьцаанд хөрвүүлнэ.

6.3 Компанийн тухай хуулийн 51.4 дэх хэсэг, МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 19.2 дахь хэсэгт зааснаар Компани нь хувьцааг нэгтгэсний үр дүнд бий болсон хувьцааны бутархай үлдэгдлийг тухайн бутархай тооны хувьцаатай хувьцаа эзэмшигчийн саналыг үндэслэн (i) ТУЗ-өөс тогтоосон үнээр Компани эргүүлэн худалдан авах, эсхүл (ii) бутархай тооны хувьцаатай хувьцаа эзэмшигч Компанид нэмж хөрөнгө оруулалт хийж, Компани түүнд тохирох тооны хувьцаа нэмж гарган, эсхүл халаасалсан хувьцаанаас гарган эзэмшүүлэх замаар бутархай тооны хувьцааг бүхэлдэж болно. Хувьцааг нэгтгэх болон бутархай хувьцааг бүхэлдэх жишээг Төслийн 5.5 дахь хэсгээс харна уу.

Долоо. Өөрчлөн байгуулж дуусгах

7.1. Компанийг Төсөлд заасан нөхцөл, журмын дагуу өөрчлөхөд түүний эрх, үүрэг, хариуцлага ХХК-д шилжинэ.

7.2. Компанийн нийт ажилтнууд, хөрөнгийг ХХК-д шилжүүлэх бөгөөд тэдгээртэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

7.3. СЗХ-ны зөвшөөрөл гарсны дараа өөрчлөн байгуулагдсан "Хөвсгөл усан зам" ХХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээр Компанийн хувьцааг нэгтгэж, өөрчлөн байгуулж дууссанд тооцно.



ХӨВСГӨЛ УСАН ЗАМ ХК

Хөвсгөл, Хатгал, 1-р хэсэг, Хатгал тосгон.
Улаанбаатар оффис, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Гутал ХК байр.
Утас: 976 7577-8888, 8888-3550
И-мэйл: urjinbadam.ch@nomin.net
Вэб: www.nomin.mn

2023 оны 01 дүгээр
сарын 27-ны өдөр

Дугаар: 02

Улаанбаатар
хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

Санхүүгийн тайлангийн талаарх
ТҮЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.15 дахь хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 01-р сарын 27-ны өдрийн ээлжит бус хурлын санал хураалтын дунг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

- Компанийн 2022 оны 09-р сарын 30-ны өдрийн байдлаарх санхүүгийн тайланд хийсэн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

М.ӨЛЗИЙБАТ



ХӨВСГӨЛ УСАН ЗАМ ХК

Хөвсгөл, Хатгал, 1-р хэсэг, Хатгал тосгон.
Улаанбаатар оффис, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Гутал ХК байр.
Утас: 976 7577-8888, 8888-3550
И-мэйл: urjinbadam.ch@nomin.net
Вэб: www.nomin.mn

2023 оны 01 дүгээр
сарын 27-ны өдөр

Дугаар: 03

Улаанбаатар
хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

ТҮЗ-ийн тогтоосон нэгж хувьцааны үнэлгээг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.12, 62.1.15 дахь хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 01-р сарын 27-ны өдрийн ээлжит бус хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

- Үнэт цаасны зах зээлд үнэлгээ хийх эрх бүхий хараат бус үнэлгээний байгууллага болох "Хүлэгт хүннү аудит" ХК-ийн 2023 оны 01-р сарын 18-ны өдрийн Бизнесийн үнэлгээний тайланг үндэслэн ТҮЗ-ийн 2023 оны 01-р сарын 20-ны өдрийн хурлаар "Хөвсгөл усан зам" ХК-ийн нэгж хувьцааны үнэлгээг 3,736 (гурван мянга долоон зуун гучин зургаа) төгрөгөөр тогтоосныг баталсугай.
- Тус компанийн хувьцааг нэгтгэх, компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх төслийг хэрэгжүүлэх, уг төсөлд заасны дагуу компанийн хувьцааг худалдаж авах үйл ажиллагааг энэхүү тогтоолоор батлагдсан үнийн дагуу гүйцэтгэхийг төлөөлөн удирдах зөвлөлөөс томилогдсон компанийн хувьцааг нэгтгэх, компанийн хэлбэрийг өөрчлөх ажлыг зохион байгуулах комисс болон гүйцэтгэх захирал Ч.Үржинбадам нарт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

М.ӨЛЗИЙБАТ



ХӨВСГӨЛ УСАН ЗАМ ХК

Хөвсгөл, Хатгал, 1-р хэсэг, Хатгал тосгон.
Улаанбаатар оффис, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Гутал ХК байр.
Утас: 976 7577-8888, 8888-3550
И-мэйл: urjinbadam.ch@nomin.net
Вэб: www.nomin.mn

2023 оны 01 дүгээр
сарын 27-ны өдөр

Дугаар: 04

Улаанбаатар
хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.4 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 01-р сарын 27-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ Нь:

- "Хөвсгөл усан зам" ХК-ийн хэлбэрийг өөрчилж "Хөвсгөл усан зам" хязгаарлагдмал хариуцлагатай компани болгохоор шийдвэрлэсүгэй.
- Компанийн хэлбэрийг өөрчлөх ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэх, Санхүүгийн зохицуулах хороо, "Монголын хөрөнгийн бирж" ХК-аас холбогдох зөвшөөрөл авах, улсын бүртгэлд бүртгүүлэхийг төлөөлөн удирдах зөвлөлөөс томилогдсон компанийн хувьцааг нэгтгэх, компанийн хэлбэрийг өөрчлөх ажлыг зохион байгуулах комисс болон гүйцэтгэх захирал Ч.Үржинбадам нарт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

М.ӨЛЗИЙБАТ

